

Мормоны Номон дахь эмэгтэй баатрууд


Бидэнд сайн үлгэр жишээ боддог олон эмэгтэй Мормоны Номонд гардаг. Цуглуулгандаа нэмэх гурван баатрын карт энд байна. Бид бүгдийнх нь нэрийг мэдэхгүй ч гэсэн тэдний үлгэр жишээнээс суралцаж чадна. Та нар хэрхэн Мормоны Номын эдгээр эмэгтэй шиг байж чадах вэ?



Та нар тэдэн шиг өөр эмэгтэйг судруудаас олж чадах уу? Тэдэнд зориулан өөрийнхөө баатрын картыг хийгээд, зургаа бидэнд илгээгээрэй!

- 1 Нифай 7:19. Эдгээр эмэгтэй Нифайн талд зогсож, эр зоригоо харуулсан. Тэд хэн байсан бэ?
- 2 Нифай 5:6. Эдгээр эмэгтэй Бурханд итгэж, Нифайг дагаж аглаг буйд руу явсан. Тэд хэн байсан бэ?
- Алма 56:47-48. Эдгээр эмэгтэй хүүхдүүддээ Бурханы тухай заасан. Тэд хэн байсан бэ?

[Харуулжээ нийгмийн үүлэг, гар, нэ нифайн 'дихо нолод ренхе нийгмийн :дүүллүнд]

 Энэ даалгаврын хуудсыг хайчилж, нугалаад, хадгал.


ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЖАРЭД БЭЖСТРАНД



Би итгэж чадна.

Лемонайн эхнэр Аммоныг Бурханы бошиглогч мөн гэдэгт итгэлтэй байсан. Та нар өнөөгийн бошиглогч, төлөөлөгчдөд итгэснээр Лемонайн эхнэртэй адил болж чадна.

- Алма 19:2–5, 8–10-ыг үзнэ үү.
- Ерөнхийлөгч Монсоны чуулган дээр хэлсэн үгийг үз. Тэр бол Бурханы бошиглогч гэдэгт та нар итгэдэг үү?
- Би өөртөө . . . даалгавар өгөв.



Би гэрчлэлтэй болж чадна.

Сариа нөхөр Лихай нь Бурханы бошиглогч мөн гэсэн гэрчлэлтэй болсон. Та нар өөрийн гэсэн гэрчлэлтэй болж, гэрчлэлээ бусадтай хуваалцсанаар Сариятай адил болж чадна.

- 1 Нифай 5:7–8-ыг унш.
- Гэрчлэлээ бич эсвэл гэрчлэлээ найзтайгаа эсвэл гэр бүлийнхээ гишүүнтэй хуваалц.
- Би өөртөө . . . даалгавар өгөв.



Би үзэл бодлоо илэрхийлж чадна.

Мориантон ёс бус хүн байсан. Тэр шивэгчингүүдийнхээ нэгийг зодсон бөгөөд тэр эмэгтэй Мориантоны хийж байгаа зүйлүүдийг ахмад Моронайд хэлэхээр шийджээ. Та нар буруу зүйлийн талаар нуулгүй хэлснээр энэ шивэгчинтэй адил болж чадна!

- Алма 50:30–31-ийг унш.
- Хэрэв хэн нэгэн чамайг дээрэлхвэл эсвэл өөр хэн нэгнийг дээрэлхэж байгааг харвал энэ талаар итгэж явдаг насанд хүрсэн хүндээ хэлээрэй.
- Би өөртөө . . . даалгавар өгөв.
